

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Санамж бичгийг дэмжин баталгаажуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны холбогдох этгээд болох “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-тай 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг хүлээн зөвшөөрч, хүчин төгөлдөр байдлыг дэмжин баталгаажуулсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОПША